Анагаах ухааны ёс зүй, эрхзүйн хичээлийн хөтөлбөрийг судлах нь

*О.Болорсайхан[1], Э.Ганбат[2], **Б.Мядагмаа[3], Б.Ширчиндоо[4], М.Үзмээ[5], С.Оюунцэцэг[6]***
ЭС-ийн АУЭЗБС тэнхимийн дэд профессор,АШУУИС[1]
ЭС-ийн АУЭЗБС тэнхимийн багш,АШУУИС[2]
БМИУЗ мэргэжилтэн[3]
МАУОУС арга зүйч[4]
БАС, Харилцааны ур чадварын тэнхимийн дадлагажигч багш,АШУУИС[5]
БАС, Харилцааны ур чадварын тэнхимийн эрхлэгч,АШУУИС[6]
Цахим шуудан: bolorsaikhan@mnums.edu.mn, Утас 99089566

Түлхүүр үг:

Анагаах ухаан,
ёс зүй,
эрх зүй,
сургалтын төлөвлөгөө

Товч утга:

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрх зүйн боловсрол олгоход оюутанд эмнэлзүйн практикт ёс суртахууны мэдлэг, шүүмжлэлт сэтгэлгээг бодит тохиолдлуудад хэрхэн ашиглахыг заах, ёс зүй, эрх зүйн боловсролоор дамжуулан ирээдүйн анагаахын мэргэжилтнүүдэд зөв зан чанарыг төлөвшүүлэх хэрэгтэй.

Анагаахын сургуулийн ёс зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт феминист ёс зүй, шударга ёс гэсэн ойлголтыг авч үздэг нь ёс зүйн чиг хандлагыг төрөлжүүлж, сургалтанд онцгой ач холбогдолтой.

Ёс зүй, эрх зүйн хичээлийг заах арга нь танин мэдэхүйн болон зан үйлийн ур чадвар, түүний дотор хувь хүний зан чанарын сайн сайхан байдлыг таниулах зэрэг өргөн хүрээг хамардаг.

Монгол улсад ёс зүйн хичээлийн сургалтын төлөвлөгөөнд нийгмийн эрүүл ахуй, Анагаах ухааны түүх ёс зүй нэршлээр 1955 оноос орж эхэлсэн байна.

Анагаахын боловсрол олгож байгаа их дээд сургууль, төгсөлтийн өмнөх ба дараах сургалтын ёс зүйн хичээлийн хөтөлбөрийг агуулга, багц багийг улам боловсронгуй болгох хэрэгцээг үндэслэн энэхүү судалгааг хийх болсон.

Зорилга: Монгол улсад анагаахын боловсрол олгодог их дээд сургуулиудын ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулан судлах

Судалгааны арга зүй: Тоон болон чанарын судалгааны аргаар анагаахын сургуулиудын сургалтанд хэрэгжиж байгаа ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг сургалтын төлөвлөгөөний баримт бичгийг харьцуулан судлах зэргээр судалгааг хийж гүйцэтгэсэн.

ҮР ДҮН: Монгол улсад анагаахын боловсрол олгодог 12 их дээд сургуулиас ёс зүйн хичээлийн агуулгын хувьд Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй нэршлээр 6 сургууль, Анагаах ухааны ёс зүй, Эмч, эмнэлгийн ажилтын ёс зүй, эрх зүй нэршилээр, судлах хэлбэрийн хувьд заавал судлах, сонгон судлах хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнээс 2 сургууль заавал болон сонгон судлах, 6 сургууль заавал судлах, 2 сургууль лекц, семинари, төсөл хэлбэрээр сургалтын төлөвлөгөөнд тусгажээ.

Дүгнэлт: Сургууль болгонд ёс зүйн хичээлийн агуулга болон судлах хэлбэр янз бүрээр тусгагдсан байна. Цаашид олон улсын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулан судалж нэршил болон агуулгыг боловсронгуй болгож цөм хөтөлбөрийг боловсруулах шаардлага тулгарч байна.

Үндэслэл: Дэлхий дахинд сүүлийн 30 жилийн хугацаанд, анагаахын оюутнуудын ихэнх (64-84%) нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өндөр түвшинд стандартын дагуу хүргэхэд ёсзүйн практик нэн чухал болохыг хэд хэдэн судалгаанууд харуулаад байна.[1,2] Мөн оюутнууд нь анагаахын ёс зүйн талаар илүүтэйгээр суралцах хүсэлтэй байгааг (95% нь) илэрхийлсэн байдаг.

Орчин үед дэлхий улс орнуудад Гиппократын тангаргийн үзэл санаа, түүний агуулга, зарчим нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн болон эрх зүйн хэм хэмжээ болох “Ёс зүйн дүрэм”, “Эрүүл мэндийн хууль”-д тусгагдсан төдийгүй Эрүүгийн хуулиар хамгаалагдсан байдаг. Аристотель “ЁС ЗҮЙ” бол мэдлэг биш, харин үйлдэл юм гэж сургасан нь өнөө ч үнэ цэнээ алдаагүй улам ч тулгамдаж буй асуудал болсоор байна.[3]

Манай улсад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой санал, гомдол сүүлийн жилүүдэд 2-3 дахин нэмэгдэж, иргэдээс 7 хоногт дунджаар 900 орчим санал ирж байгаагийн 60-70 хувийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар эзэлж байна. Ёс зүйн сургалтын хөтөлбөрийг эрх зүйн ерөнхий болон анагаах ухааны эрх зүйн сургалтын хөтөлбөртэй уялдуулан, тэдгээрийн харилцан хамаарлыг шинжлэх ухааны, практик тохиолдолд үндэслэн зөв тодорхойлж сургалтын тогтолцоо, бүтцийн нэгжийг зөв оновчтой болгох шаардлага бидэнд тулгарч байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2004 онд “Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглал”-ыг баталж, сургалт боловсролоор дамжуулан хүн бүр, бүхий л нийгмийн байгууллага хүний эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах, биелүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч тунхагласан билээ. Энэхүү тунхаглалын 8 дугаар зүйлд “Хүний эрхийн боловсрол сургалтыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг сургалтын хичээлийн хөтөлбөрт нийцүүлэх замаар боловсруулах буюу хөхиүлэн дэмжих тухай заасан байдаг.

ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 33-р чуулганаар “Био ёс зүй болон хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг 2005.10.19-ны өдөр баталсан байна. ЮНЕСКО-гийн Био ёс зүйн үндсэн сургалтын хөтөлбөр, Ёс зүйн багш бэлтгэх курс (ETTC) зэргийг анагаах, эрүүл мэндийн чиглэлээр сургалтын үйл ажиллагааг явуулж буй их дээд сургуулийн суралцагчид болон судлаачдад түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээдэг. Анагаах ухааны ёс зүйн хичээлийг анагаахын сургуулиудын сургалтын хөтөлбөрт орхигдуулах өрөөсгөл хандлага түгээмэл байдаг.

Хонконгын их сургуульд сүүлийн 6 жилд хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад мэргэжлийн ёс зүйн хичээлийг заавал сурах хөтөлбөрт нь тусгаснаар мэргэжлийн алдааг бууруулж буй судалгааны үр дүн гарсан байна. Иймд эрүүл мэндийн мэргэжлийн хөтөлбөрийн ёс зүй, эрх зүйн хичээлийн агуулгыг судлан, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах зорилгоор уг судалгааг хийв.

Зорилго: Анагаах ухааны ёс зүй, эрх зүй хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг харьцуулан, үр дүнг тооцох

Зорилт:

1. Монгол улсад анагаахын боловсрол олгодог их дээд сургуулиудын ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулан судлах
2. Төрийн өмчийн их сургуулийн хөтөлбөрийн ёс зүй, эрх зүйн хичээлийн агуулгыг үнэлэх

Судалгааны арга зүй:

Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар гүйцэтгэсэн.

Тоон болон чанарын судалгааны аргаар анагаахын сургуулиудын сургалтанд хэрэгжиж байгаа ёс зүй, эрх зүйн хичээлийн хөтөлбөр, хөтөлбөрийн агуулгыг сургалтын төлөвлөгөөний баримт бичгийг харьцуулан судлах зэргээр судалгааг хийж гүйцэтгэсэн. Монгол улсад анагаах эрүүл мэндийн чиглэлээр тасралтгүй 80 жил сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн ёс зүйн хичээлийн хөтөлбөрийг 1955 оноос одоог хүртэлх хугацаанд хэрхэн яаж өөрчлөгдөж одоог хүрсэнийг харьцуулан судлав.

Судалгааны үр дүн: Монгол улсад 2021 оны байдлаар анагаах, эрүүл мэндийн чиглэлээр сургалтын үйл ажиллагааг эрхэлж буй 12 их дээд сургууль байсан бөгөөд бакалаврын сургалт хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ёс зүйн хичээлийн багц цаг, судлах хэлбэр, хичээлийн хэлбэр зэрэг үзүүлэлтээр судласан.

Хүснэгт 1. Ёс зүйн хичээлийн судалгаа

№	Сургууль	Багц цаг	Судлах хэлбэр		Хичээлийн хэлбэр		
			Заавал	Сонгон	Лекц	Семинари	Төсөл
1	АШУҮИС	55	√	√			
2	Оточ манарамба их сургууль	45	√				
3	Аварга дээд сургууль	3	√				
4	Этүгэн их сургууль	74			√	√	√
5	Глобал удирдагч дээд сургууль	1	√				
6	Энэрэл дээд сургууль	6	√				
7	Их засаг олон улсын их сургууль	3	√				
8	Олон улсын Улаанбаатар их сургууль	3			√	√	
9	Монголын үндэсний их сургууль	45	**ө**				
10	Ач анагаах ухааны их сургууль	20	**ө**				
11	Шинэ анагаах ухааны их сургууль	6	√	√			
12	Эмзүйн шинжлэх ухааны их сургууль	14	√				
	Дундаж	24.8	8/2	2	2	2	1


Анагаах, эрүүл мэндийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ёс зүйн хичээлийн дундаж багц цаг 24.8 байна. Этүгэн ИС, АШУҮИС хамгийн өндөр багц цагтай (74, 55/ байна. Глобал удирдагч дээд сургуулийн ёс зүйн багц цаг хамгийн бага багц цагтай байна. Уг хичээлийг судлах хэлбэрийн хувьд заавал судлах, сонгон судлах хэлбэрээр судлагдаж байна. АШУҮИС, Шинэ АУИС заавал болон сонгон судлах боломжтой сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна. Оточманарамба их сургууль, Аварга дээд сургууль, Глобал удирдагч дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Их засаг олон улсын их сургууль, Эмзүйн шинжлэх ухааны их сургууль зэрэг 6 сургууль заавал судлах хэлбээрээр тусгасан байна. Этүгэн их сургууль, Олон улсын Улаанбаатарын их сургууль лекц, семинари, төсөл хэлбэрээр хичээлийн тусгасан байна.

Хүснэгт 2. Ёс зүйн хичээлийн агуулга

Д/д	Сургууль	Анагаах ухааны ёс зүй	Хүний хөгжил, ёс зүй	Эмч, эмнэлгийн ажилтын ёс зүй, эрх зүй	Био-анагаахын ёсзүй	Ёс зүй	Нийгмийн ёс зүй	Эмчийн ёс зүй	Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй	Хүний хөгжил, харилцааны ур чадвар	Хүүль, эрх зүй, ёс зүйн асуудал	Ажилчдын мэргэжлийн ёс зүй, үйлчлүүлэгч-н сэтгэл ханамж	Нийгмийн эрүүл мэнд,мэргэжилтний ур чадвар	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй	Сувилагчийн ёс зүй
1	АШУҮИС	√		√ √	√	√	√								
2	Оточманарамба их сургууль	√									√			√	
3	Аварга дээд сургууль													√	
4	Этүгэн их сургууль			√	√	√				√				√	
5	Глобал удирдагч дээд сургууль			√					√			√			√
6	Энэрэл дээд сургууль			√	√										
7	Их засаг олон улсын их сургууль													√	

8	Олон улсын Улаанбаатар их сургууль			√												
9	Монголын үндэсний их сургууль	√					√								√	√
10	Ач анагаах ухааны их сургууль	√						√						√	√	
11	Шинэ анагаах ухааны их сургууль		√					√	√							
12	Эмзүйн шинжлэх ухааны их сургууль	√	√			√				√	√					
	Дундаж	5	3	5	3	3	2	2	2	2	2	1	1	6	2	

Ёс зүйн хичээлийн агуулгын хувьд Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй нэршлээр 6 сургууль, Анагаах ухааны ёс зүй, Эмч, эмнэлгийн ажилтын ёс зүй, эрх зүй нэршилээр тус бүр сургуульд ордог байна. Сургууль болгонд ёс зүйн хичээлийн агуулга янз бүрээр тусгагдсан байна. Иймд ёс зүйн цөм хөтөлбөртэй болох шаардлагатай байна.



Зураг 1. Ёс зүйн хичээлийн цагийн өөрчлөлт (1955-2016 он)

Үр дүнгээс харахад сургалтын төлөвлөгөөнд ёс зүйн талаарх хичээлийн агуулга Нийгмийн эрүүл ахуй, Анагаах ухааны түүх ёс зүй нэршлээр 1955 ондлекц, дадлага, семинар бүхий 90 цаг, 1975 онд 12 цагаар нэмэгдэж 102 цаг, 1985 онд 76 цагаар багасгаж 26 цаг болтолоо бууруулсан байна. Харин 1990 онд 102 цагаар нэмэгдэж 128 цаг буюу 108 цагийн лекц, 20 цагийн лаборторийн ажил, 2003 онд 48 цагаар буурч 80 цаг үүнээс 16 цагийн лекц, 64 цагийн практик ажил, 2008 онд 96, 2010 онд 112, 2016 онд 96 цагийн лекц семинарын хичээл орж байсан байна. Эмчийн ёс зүй нэршлээр 1985 онд 26 цаг, 2008 онд 96 цаг буюу лекц, лабораторийн ажил, семинар, курсын ажил хэлбэрээр, 2016 онд 96 цаг лекц, семинарын хэлбэрээр тус тус орсон байна. Анагаах ухааны түүх, харилцааны ёс зүй нэршлээр 1955 онд 54 цаг, 1993 онд 36 цаг, 2003 онд 228 цаг, харин 2004 онд 40 цагийн хичээл орж байсан байна. Харилцааны ур чадвар нэршлээр 2008 онд 48 цаг, 2010 онд 32 цаг, 2016 онд 48 цаг тус тус орж байна. 2019-2020 оны хичээлийн жилд ёс зүйн хичээл Анагаах ухааны ёс зүй нэршлээр 96 цаг буюу 16 цагийн лекц, 24 цагийн семинар, 8 цагийн бататгах, 48 цагийн бие даалт гэсэн байдлаар орж байна. Цаашид олон улсын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулан судалж давхардалыг арилгах боломжтой гэж үзэж байна. Одоогоор Ёс зүйн чиглэлээр Анагаах ухааны ёс зүй, Биоанагаахын ёс зүй, Нийгмийн ажлын ёс зүй, Эм зүйчийн ёс зүй, Ёс зүйн үндэс, Сэтгэлгээний түүх соёл, Хүний хөгжил, ёсзүй нэршлээр тус тус орж байна.

Хүснэгт 3. Төгсөлтийн өмнөх сургалтын төлөвлөгөөнд ёс зүй, эрх зүйн хичээлийн судалгаа

Д/д	Сургууль	Мэргэжил	Кредит	Судлах хэлбэр
1	Анагаах ухааны сургууль	Анагаахын 4 дамжаа	2 кр	Үндсэн хичээл
2	Биоанагаах	Биоанагаах 3 дамжаа		
3	Нийгмийн эрүүл мэндийн сургууль	Эрүүл мэндийн нийгмийн ажил 2 дамжаа		
4	Хүний хөгжил, ёс зүй	Эрүүл мэндийн суурь боловсрол 1 дамжаа	2 кр	сонгон
5	Сэтгэлгээний түүх, соёл		2 кр	сонгон
6	Эмзүйн сургууль	Эмзүйн 3 дамжаа	1 кр	сонгон
7	Уламжлалт анагаах ухааны сургууль	Зүү төөнүүр бариа заслын 3 дамжаа	1 кр	сонгон
Дипломын ангиудад ёс зүйн хичээл орж байгаа мэргэжлийн чиглэл				
Д/д	Сургууль	Мэргэжил	Кредит	Судлах хэлбэр
1	Сувилахуй	Сувилагч	1 кр	Үндсэн хичээл
2	Эм зүй	Эм найруулагч	1 кр	Үндсэн хичээл
3	Нүүр ам судлалын сургууль	Нүүр амны техникч	1 кр	Үндсэн хичээл
4	Анагаах ухааны сургууль	Эмнэлгийн тоног төхөөрөмж	1 кр	Үндсэн хичээл
5	Анагаах ухааны сургууль	Дүрс оношилгооны техникч	1 кр	Үндсэн хичээл
Сувилахуйн сургуулийн Бакалаврын түвшинд “Анагаах ухааны ёс зүй” хичээл				
1	Сувилахуй	Сувилагч	Ордоггүй	
2		Эх барихуй	2 кр	Үндсэн хичээл
3		Хөдөлгөөн засалч	2 кр	Үндсэн хичээл
Эрүүл мэндийн эрх зүй хичээл				
1	Эрүүл мэндийн суурь боловсрол 1 дамжаа		2	сонгон
2	Эрүүл мэндийн суурь боловсрол 2 дамжаа		2	сонгон

Дээрх үр дүнгээс харахад Анагаах ухааны ёс зүй, Биоанагаахын ёс зүй, Нийгмийн ажлын ёс зүй, Сувилахуйн сургуулийн “Ёс зүйн үндэс” хичээл дипломын ангиудад үндсэн хичээлээр, харин Нүүр ам судлал, Уламжлалт анагаах ухаан бакалаврын сургалтын төлөвлөгөөнд ёс зүйн хичээл тусгагдаагүй байна. Сувилахуйн сургуулийн дипломын болон бакалаврын ангиудад “Анагаах ухааны ёс зүй” хичээлийг заадаг ёс зүйн мэргэжлийн багш одоогоор хомс байна. Эрх зүйн хичээл Эрүүл мэндийн суурь боловсрол 1, 2 дамжаанд 2 багц цагийн багтаамжтай сонгон суралцах хичээлийн хэлбэрээр тусгагдсан байна. Бусад мэргэжил, дамжаанд одоогоор тусгагдаагүй байна. Ёс зүй, эрх зүйн хичээлийн агуулгыг судлахад дараах судалгааны үр дүнтэй байна.


Хүснэгт 4. Ёс зүй, эрх зүйн хичээлийн агуулгын судалгаа

№	Сургууль	Мэргэжил анги	Хичээлийн нэр	Агуулга
1	Анагаах ухааны сургууль	Анагаах ухааны сургууль 4 дамжаа	Анагаах ухааны ёс зүй	Хэрэглээний ёс зүй Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэглээний ёс зүй
2	Биоанагаахын сургууль	Биоанагаахын 3 дамжаа	Биоанагаахын ёс зүй	Мэргэжлийн ёс зүй
3	Нийгмийн эрүүл мэндийн сургууль	Эрүүл мэндийн нийгмийн ажил 3 дамжаа	Нийгмийн ажлын ёс зүй	Мэргэжлийн ёс зүй
4	Эмзүйн сургууль	Эмзүйн 3 дамжаа	Эм зүйчийн ёс зүй	Мэргэжлийн ёс зүй
5	Уламжлалт анагаах ухааны сургууль	Зүү төөнүүр бариа заслын 3 дамжаа	Ёсзүйн үндэс	Онол, зарчим
6	Хүний хөгжил, ёс зүй	1 дамжаа	Premedical-д сонгон суралцах хичээлийн агуулга	Хүний хөгжлийн үзэл баримтлал, харилцааны ёс зүй
7	Сэтгэлгээний түүх, соёл	2 дамжаа		Ёс зүйн уламжлалт болон орчин үеийн онол сургааль

		Эрх зүйн хичээлийн агуулга	
1	Эрүүл мэндийн эрх зүй	1 дамжаа	Эмнэлгийн эрх зүйн хичээл нь нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээ, эрүүл ахуй-ариун цэврийн үйл ажиллагааны хүрээнд иргэд-эрүүл мэндийн байгууллага, өвчтөн эмнэлгийн ажилтны хооронд үүссэн харилцааг зохицуулж эрх зүйн хэм хэмжээний актуудын талаарх цогц чадамжийг биоанагаахын сонгон сургалтын түвшинд

Анагаах ухааны сургууль, Биоанагаахын сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Эмзүйн сургууль, Уламжлалт анагаах ухаан сургуулийн бакалаврын сургалтанд орж буй ёс зүйн хичээлийн агуулгыг судлахад хэрэглээний ёс зүй, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэглээний ёс зүй, мэргэжлийн ёс зүй, онол зарчим гэх мэтээр орж байгааг зөвхөн мэргэжлийн ёс зүй түүн дотроо салбарын чиглэлээр сургалтын төлөвлөгөөнд хичээлийн нэрийг тусгах цаашид “Био ёс зүй” хичээлийн хөтөлбөрийг сургалтанд тусгах нь нэн чухал байна.

Монголын Анагаах ухааны эрх зүйн холбоо (НҮТББ)-ны 2019 онд хийсэн судалгаагаар 2005-2019 онд 360 гаруй эмнэлгийн мэргэжилтэнд холбогдох 232 эрүүгийн хэргийн материалд дүн шинжилгээ хийхэд хууль эрх зүйн мэдлэг, чадвар дутагдсан шалтгаантай мэргэжлийн үйл ажиллагааны алдаа, зөрчил 62 хувь эзэлж байгаа нь эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтанд эрх зүйн сургалт зайлшгүй чухал болохыг харуулж байна.



Зураг 2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хэрэг маргаан тохиолдлын тоо

Дээрх хүснэгтээс харахад Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжлэн магадлалын тайлан дахь “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой хэрэг маргааны үед хийгдсэн шинжилгээний тохиолдол өсөх хандлагатай байна.

Нөхцөл байдлын SWOT шинжилгээ

Ёс зүйн хичээлийг зохион байгуулж буй 12 сургуулийн бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэж нийтлэг онцлог талуудаар нь дараах SWOT шинжилгээг хийлээ.

Хүснэгт 6. Хөтөлбөрүүдэд хийсэн SWOT шинжилгээ

Давуу талууд	*Дутагдалтай талууд*
• *Ихэнх сургуулиуд ёс зүйн хичээл янз бүрийн нэршлээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.* • *Заавал судлах болон сонгон суралцах хэлбэрээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан.*	• *Хичээлийн цаг бага* • *Янз бүрийн нэршлээр орж байна.* • *Бие даасан тэнхим байхгүй.* • *Багшлах боловсон хүчин хомс.* • *Хичээлийг хүргэх хэлбэр цөөн*
Сайжруулах боломж	***Хөтөлбөрийн эрсдэл***
• *Мэргэжлийн ёс зүй, Био ёс зүйн хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тусгах* • *Ёс зүй, эрх зүйн хичээлийн уялдаа холбоог сайжруулах* • *Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах*	• *Ард иргэд олон нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хандлагыг сайжруулах хэрэгтэй гэж үздэг.* • *Ард иргэд, үйлчлүүлэгчдийн ёс зүйн боловсрол доогуур*

Хэлцэмж: Орчин үед дэлхий дахинд мэргэжлийн ёс зүйн асуудлаар сургалт, судалгааны ажил улам өргөн цар хүрээтэй болж байна. ЮНЕСКО-ийн зүгээс ч мэргэжлийн ёс зүйн боловсрол бол зөвхөн хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэхээс илүү амьдралын үнэт зүйл, үнэ цэнийг авчирдаг зүйл болохыг онцолж байна. *Өнөөгийн Монголын эрүүл мэндийн салбарт өндөр мэдлэг, ур чадвар бүхий иргэн шаардлагатай байгаагийн зэрэгцээ, үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс суртахуунтай мэргэжилтэн бэлтгэх нь түүнээс дутуугүй чухал байна.*

Дижитал хөдөлмөрийн эрин зуунд технологийн хурдтай өөрчлөлт шинэчлэлттэй уялдан ёс суртахуун байнга хувьсан өөрчлөгдөж байгаа хэдий ч ёс зүйн үүрэг хариуцлага хэвээр байдаг. *Нийгэм хөгжихийн хэрээр анагаахын мэргэжилтэнд тавигдах мэргэжлийн ёс суртахууны шаардлага нэмэгдэж,* анагаахын мэргэжилтнийг бэлтгэхэд мэргэжлийн ёс зүй, эрх зүйн боловсролыг эзэмшсэн, харилцааны өндөр соёлтой, хөрвөх ур чадвартай, мэдрэмжтэй, сэтгэлтэй байхыг шаардаж байна.

Судлаач Б.Цэвэлмаа нарын 2019 онд хийгдсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийн түвшин бага, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин муу байгаа нь хоорондоо шууд хамааралтай үр дүн ажиглагдаж байна. Анагаахын сургалтанд эмнэлгийн анагаах ухааны эрх зүй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, түүнтэй холбоотой үүсэх зөрчил, шинээр гарсан болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм, эрх зүйн актуудын талаарх мэдлэгийг олгосноор ёс зүйн болон эрх зүйн зөрчлийн тохиолдлын тоо буурна гэж үздэг.

Судлаач Д.Нямаажав нарын 2021 онд хийгдсэн Анагаахын сургуулийн оюутнуудад мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх асуудалд судалгааны үр дүнгээс Сайн хүн төлөвших загварыг тусгах: хөтөлбөрийн зорилго-хүншихүй, нийгэмшихүй, төлөвшихүй, хөтөлбөрийн агуулгад: баримтлах чиглэлүүд, үйл явцын төрөл, үе шатууд, арга зүйд: зүгшрүүлэг, зохион байгуулалт, хөтөлбөрийн үр дүнд баримтлах чиглэлийн чадамжууд нь хичээл бүртэй уялдах талаар томьёолсон байна. Анагаахын сургалтанд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, анагаах ухааны эрх зүй, түүнтэй холбоотой үүсэх зөрчил, шинээр гарсан болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрэм, эрх зүйн актуудын талаарх мэдлэгийг олгосноор ёс зүйн болон эрх зүйн зөрчлийн тохиолдлын тоо буурна гэж үздэг.

Дүгнэлт:

1. Ёс зүйн хичээлийн агуулгын хувьд Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй нэршлээр 6 сургууль, Анагаах ухааны ёс зүй, Эмч, эмнэлгийн ажилтын ёс зүй, эрх зүй нэршилээр тус бүр сургуульд ордог байна. Сургууль болгонд ёс зүйн хичээлийн агуулга янз бүрээр тусгагдсан байна. Иймд ёс зүйн цөм хөтөлбөртэй болох шаардлагатай байна.
2. АШУҮИС-ийн эмч бэлтгэх хөтөлбөрийн ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн боловсруулж Нүүр ам судлал, Уламжлалт анагаах ухааны бакалаврын сургалтын төлөвлөгөөнд ёс зүйн хичээлийг тусгах.Сонгон судлах хэлбэрээр сургалтын хөтөлбөрт тусгасан байгаа нь байгааг Ёс зүй, эрх зүйн хичээлийг заавал судлах хичээлээр тусгах, хөтөлбөрийн онцлогтой уялдуулж сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх

Ном зүй:

1. Д.Цэрэндагва, Б.Оюунгоо, М.Цэрэнбат, О.Болорсайхан, С.Оюунцэцэг, Д.Оюунбилэг "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн боловсрол" 2022 он
2. Б. Бурмаажав. "Анагаах ухааны ёс зүй Монголд" .Хүнийг оролцуулсан судалгааны ёс зүйн сургалт, Улаанбаатар. 2014.9.22

3. Б. Бурмаажав, Ж. Раднаабазар (2007). Анагаах ухааны ёс зүй, гарын авлага. ЭМЯ, ДЭМБ. Улаанбаатар
4. Сосорбурам.Б, Мэргэжлийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн агуулга, заах арга, сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлийн асуудалд, Мэргэжлийн ёс зүйн асуудалд (2018), 260–268;
5. Нямсүрэн.Д, Дамдинжав.Х, Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцааны соёлын түвшинд хийсэн судалгаа, 2000; хуу 60
6. Цэвэлмаа.Б “Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдлыг үнэлсэн байдал” АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл./2020)
7. Мэргэжлийн ёс зүйн асуудалд, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (2018);
8. Нямаа Ц, Даваа Ж нарын Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр 2017
9. Болормаа.С, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороодын үйл ажиллагаа, бүтцийн өнөөгийн байдал, НЭМ-ийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, 2015;
10. Кристина Е. Торрес. “Судалгааны ёс зүйн Олон улсын Удирдамжийн түүх ба тойм”. Хүнийг оролцуулсан судалгааны ёс зүйн сургалт, Улаанбаатар. 2014.9.22
11. European textbook on ethics in research. (2010) Directorate-General for Research Science, Economy and Society, pp.13-32, pp.34-48
12. C. Torres. “Судалгааны протоколыг хянах явцад гарах хувь хүний нууц ба нууцлалын асуудал”. Хүнийг оролцуулсан судалгааны ёсзүйн сургалт, Улаанбаатар. 2014.9.22
13. European textbook on ethics in research. (2010) Directorate-General for Research Science, Economy and Society, pp. 11-32, 75-96
14. Baruch A. Brody. (1998). The ethics of Biomedical research. Oxford University Press.
15. J. Karbwang. “Судалгааны таниулсан зөвшөөрөл”. Хүнийг оролцуулсан судалгааны ёсзүйн сургалт, УБ. 2014.9.22
16. Х. Дамдинжав. Таниулсан зөвшөөрөл. Ёс зүйн хичээлийн лекц. 2014
17. Guide for the care and use of laboratory animals. 8th edition. National Academes Press, Washington DC, www.nap.edu.
18. ЭМЯ. АУЁЗХХ. Амьтанд туршилт хийх биоанагаахын судалгааны ёсзүйн удирдамж, 2007.
19. Research documentation. Available from www.coursera.com
20. https://en.unesco.org/themes/ethics-science-and-technology/ethics-education
21. Bioethics Core Curriculum
22. Moeller JR, Albance TH, Garchar K, Aultman JM, Radwany S, Frate D. Functions and outcomes of a clinical medical ethics committee; a review of 100 consults. 2011. From ; http; (/www.pubmed.com.
23. Olukoya AA. Attitudes of medical students to medical ethics in their curriculum. Med Educ. 1983 Mar;17:83–86. [Crossref], [Web of Science ®], [Google Scholar]
24. Shelp EE, Russell ML, Grose NP. Students’ attitudes to ethics in the medical school curriculum. J Med Ethics. 1981 Jun;7:70–73. [Crossref], [Web of Science ®], [Google Scholar]
25. Lehrmann JA, Hoop J, Hammond KG, et al. Medical students’ affirmation of ethics education. Acad Psychiatry. 2009 Dec;33:470–477. [Crossref], [Web of Science ®], [Google Scholar]

Studying medical ethics and law lesson program

O.Bolorsaikhan[1], E.Ganbat[2], B.Myadagmaa[3], B.Shirchindoo[4], M.Uzmee[5], S.Oyuntsetseg[6]
Department of Medical education and law,MNUMS[1,3]
Mongolian national council for education accreditation,officer[3]
International school of mongolian traditional medicine,officer[4]
School of Biomedicine, Department of Communication skills teacher,MNUMS[5]
School of Biomedicine, Head Department of Communication skills,MNUMS[6]
E-mail: bolorsaikhan@mnums.edu.mn, Tel: 99089566

Key wordsS:

Medicine,
ethics,
law,
curriculum

Abstract:

Students need to be taught how to apply moral knowledge and use critical thinking in clinical practice in real-life situations, and through ethical and legal education to develop the right attitudes in future medical professionals.

The idea of studying the concept of feminist ethics and justicein the curriculum of ethics in medical school, diversifies ethical approaches and adding particular importance in teaching.

The methods of teaching ethics and law cover a wide range of cognitive and behavioral skills, including the well-being of the individual.

Ethics in Mongolia has been included in the curriculum first called as public health, medical history and ethics since 1955.

The study is based on the need to further improve the content and credit of ethics program at medical universities in their undergraduate and postgraduate programs.

Purpose: A comparative study of the content of ethics lesson program at medical universities in Mongolia

Methodology:

Quantitative and qualitative research was conducted to compare the content of the ethics lesson programwhich are implemented in medical schools using evident documents.

Results: Out of 12 universities providing medical education in Mongolia, 6 schools offer ethics lesson in the name of called Human Development, Communication Ethics and Law, and other schools offer as Medical Ethics, Physician and Medical Worker Ethics and Law and they are organized as in the form of mandatory or selective study.2 schools offer both mandatory and selective form of study, 6 schools offer mandatory, and 2 schools provide lesson in the form of lecture, seminar, and project-based training.

Conclusion:

The content and form of study of ethics lesson varies from school to school.In the future, there is a need to develop a core curriculum by comparing it with similar international programs, improving the name and content.